



## СТАТИСТИКИЙН БЮЛЛЕТЕНЬ

*Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал*



**2012 оны жилийн эцсийн байдлаар**

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ**  
**2012 ОНД**  
 (Товч танилцуулга)

**Нэг. ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**


**1. Хүн ам**

2012 оны эцэст 60.9 мянган байнгын оршин суугчтай болж 2010 оны хүн амын тооллогоос 4.4 хувиар буюу 2520 хүнээр, 2011 оны жилийн эцсийн суурин хүн амын мэдээнээс 0.8 хувиар буюу 485 хүнээр нэмэгдэв. 2000 оны хүн амын тооллогоос хойш жилд дунджаар 1.57 хувь буюу 10.4 мянган хүнээр нэмэгджээ.

**Зураг. Хүн амын тоо, өсөлтийн хувь, жил бүрийн эцэст**




**Зураг. Хүн амын жилийн дундаж өсөлт, сумаар, 2000-2012 онд**




Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжихээс өмнө буюу 1979-1989 онд бүх сумдын хүн ам жигд өссөн, 1989-2000 оны хооронд Иххэт, Мандах, Сайхандулаан, Сайншанд сумдаас бусад 10 сумын хүн амын тоо өсч байсан бол, 2000-2012 онд Айраг, Даланжаргалан, Сайншанд, Замын-Үүд сумын хүн амын тоо жилд дунджаар 0.27-8.74 хувиар өсч бусад 10 сумдынх 0.22-1.91 хувиар буурав.

Зураг. Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь



Өөрөөр хэлбэл иргэд төв, суурин газар руу шилжих нь нэмэгдсэн байна. Ялангуяа Замын-Үүд сумын хүн амын тооны өсөлт 1995 оноос эрчимжиж 2000 оноос хойш жилд дунджаар 8.74 хувиар өсчээ. Хүн амын нас, хүйсийн бүтцийг харуулах гол үзүүлэлтийн нэг бол нас, хүйсийн суварга билээ.

Зураг. Дорноговь аймгийн хүн амын нас, хүйсний суварга




2012 онд манай аймгийн хүн амд 5-14 насныхны эзлэх хувь буурсан нь зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс төрөлт буурснаар тайлбарлагдаж байсан бол 0-4 насны хүн амын эзлэх хувь 2000 оныхоос нэлээд өссөн төдийгүй аймгийн хүн амын тоонд эзлэх хувь нэмэгдсэн байна. Энэ нь 2009-2012 онд төрөлт нэмэгдсэнтэй холбоотой эерэг үзүүлэлт юм.

2000 онд 10-14 насны хүн амын эзлэх хувь хамгийн их байсан нь хэвээр хадгалагдсаар 2012 онд 20-24 насанд хамгийн их хувийг эзлэж байгаа нь дээрхи зургаас харагдаж байна. Хөдөлмөрийн насны хүн ам, тэр дундаа 20-59 насны хүн ам 2000 оны тооллогоос нэлээд өссөн байна.

Суурин хүн амын 49.97 хувь нь эрэгтэйчүүд, 50.03 хувь нь эмэгтэйчүүд юм. Нийт хүн амын 59.2 хувь нь хот (аймгийн төв), тосгонд, 16.7 хувь нь сумын төвд, 24.1 хувь нь хөдөөд амьдарч байна. 109.4 мянган кв.км нутаг дэвсгэрт 60.9 мянган хүн ам оршин суудаг бөгөөд 1 кв.км нутаг дэвсгэрт 0.56 хүн ногдож байна. Замын-Үүд, Сайншанд, Даланжаргалан сумын хүн амын нягтрал аймгийн дунджаас дээгүүр байна.

**Зураг. Хүн амын насны бүтэц, хувиар, 1989, 2000, 2012 он**




Дорноговь аймгийн хүн амын тоонд насны ангилал тус бүрийн эзлэх хувийн жин 2012 онд 2000 оныхоос өөрчлөгдсөн байна. 2000 онд хүн амын 36.2 хувийг хүүхэд (0-14нас), 60.3 хувийг хөдөлмөрийн насны (15-64нас), 3.5 хувийг тэтгэвэрийн насны хүн ам эзэлж байсан бол хүн

амд хүүхэд, өндөр настны эзлэх хувь жилээс жилд буурсаар 2012 онд 28.9 хувийг хүүхэд, 67.9 хувийг хөдөлмөрийн насны, 3.2 хувийг тэтгэвэрийн насны хүн ам эзлэх болжээ.

Хүн амын насны бүтцийн өөрчлөлтийг илүү харуулж чадах, эдийн засгийн тодорхой ач холбогдолтой үзүүлэлт бол хүн ам зүйн ачаалал юм. Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, хөгшдийн харьцааг хүн ам зүйн ачаалал гэнэ. Хүн ам зүйн ачаалал буюу хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, өндөр настны тоо нь хүн амын нийгэм, эдийн засгийн чухал үзүүлэлтийн нэг юм. Хүн ам зүйн ачаалал 1979 онд 99.5 хувь, 1989 онд 90.9 хувь, 2000 онд 66.0 хувь, 2010 онд 48.9 хувьд хүрч тооллогоос тооллогын хооронд буурч 2012 онд 47.3 хувьд хүрлээ.

**Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2008-2012 он**



2012 онд Дорноговь аймагт 798 хүү, 789 охин нийт 1587 шинэ хүн мэндэлж, 373 хүн нас барж хүн амын цэвэр өсөлт 1214 болжээ. Өмнөх онтой харьцуулбал төрсөн хүүхдийн тоо 4.1 хувиар өсч, нас барсан хүний тоо 11.8 хувиар буурсан бол суурь он буюу 2008 онтой харьцуулахад төрсөн хүүхдийн тоо 24.1 хувиар, нас барсан хүний тоо 19.9 хувиар өссөн байна. Төрсөн хүүхдийн хүйсний харьцаа 101.1, нас барсан хүний хүйсний харьцаа 198.4 байна. Монгол Улсын хүн ам зүйн олон жилийн судалгаанаас үзэхэд төрөх үеийн хүйсийн харьцаа дунджаар 103-104 хооронд байдаг зүй тогтолтой. Амьдралын эхний жилүүдэд эрэгтэй хүүхдийн нас баралт илүү байж, цаашдаа хүйсийн харьцаа тэнцвэржиж байснаа нас ахих тутам буурдаг ажээ.

Хүн амын хүйсийн харьцаа (100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо) 2012 онд 99.9 байгаа нь 2011 онтой адил, 2008 оноос 3.4 пунктээр нэмэгдсэн байна. Хүйсийн харьцаа 40-өөс дээш насанд, нас

ахих тутам буурч байснаа 70, түүнээс дээш насанд хүйсийн харьцаа 57.6 түүнээс бага болж огцом буурсан байна. Энэ нь эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийнхээс харьцангуй их байдагтай холбоотой. Насны бүлэг дэх хүйсийн харьцаа нь төрөх үеийн хүйсийн харьцаа, нас баралтаас гадна хүйсийн ялгаатай шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалдаг.

Хүн амын шилжих хөдөлгөөн нь аймаг, сумын хүн амын тооны өсөлт, өөрчлөлтийг илэрхийлдэг үндсэн үзүүлэлтийн нэг юм. 2012 онд Дорноговь аймагт бүртгэлтэй шилжин ирсэн хүний тоо 877, бүртгэлтэй шилжин явсан хүний тоо 1002 болж цэвэр шилжилт -125 байгаа нь өмнөх оноос 380-аар, 2008 оноос 803-аар буурлаа.

Шилжилт хөдөлгөөний урсгал 2005-2008 онд эерэг чиглэлтэй байсан бол 2009 онд бусад аймаг, нийслэл рүү чиглэсэн сөрөг чиглэлтэй, цэвэр шилжилт нь хасах тэмдэгтэй байжээ. 2010, 2011 онд шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент +0.42 болж 2009 оноос 0,55 пунктээр нэмэгдэж байсан бол 2012 онд -0.21 болж 0.63 пунктээр буурсан үзүүлэлт гарлаа.


Шилжин явсан хүн амын 64.8 хувь нь Улаанбаатар хот, 6.8 хувь нь Говьсүмбэр аймаг, 6.6 хувь нь Өмнөговь аймаг руу, шилжин ирэгсдийн 40.0 хувь нь Улаанбаатар хот, 6.7 хувь нь Хэнтий аймаг, 6.6 хувь нь Сүхбаатар аймгаас тус тус шилжин ирж, явсан нь хамгийн өндөр хувь байна.

## 2. Өрхийн зарим үзүүлэлт

2012 оны эцэст 17901 өрхтэй болсон бөгөөд энэ нь өмнөх оныхоос 2.7 хувиар буюу 496 өрхөөр буурч, 2008 оноос 11.1 хувиар буюу 1793 өрхөөд нэмэгдэж, нэг өрхөд ногдох хүний тоо 3.4 болжээ.


2010 оны тооллогоор нийт өрхийн 58.6 хувь нь аймгийн төв, тосгонд, 41.4 хувь нь сумын төв, хөдөөд амьдарч байсан бол 2012 онд 58.2 хувь нь аймгийн төв, тосгонд, 41.8 хувь нь сумын төв, хөдөөд амьдарч байгаа нь хотожсон аймаг болохыг харуулж байна.

Зураг. Өрхийн нийгмийн зарим үзүүлэлт. 2007-2012 он



Өрх, хүн амын нийгмийн зарим үзүүлэлтийг 2011 онтой харьцуулахад эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо 16.3 хувиар буурч, 8 түүнээс дээш ам бүлтэй өрхийн тоо 3.8 хувиар, эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо 5.4 хувиар, өндөр настай, ганц бие өрхийн тоо 25.4 хувиар, 16 хүртэл насны 4-өөс дээш хүүхэдтэй өрхийн тоо 67.5 хувиар өсчээ.

Зураг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, 2008-2012 он



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2030 болж өмнөх оныхоос 9.3 хувиар, 2008 оноос 27.3 хувиар нэмэгдсэн байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 9.6 хувийг 0-15 насны хүүхэд эзэлж байна.

Өнчин хүүхдийн тоо 2012 онд 764 болж 2011 оноос 2.9 хувиар, 2008 оноос 14.0 хувиар буурлаа. Нийт өнчин хүүхдийн 7.1 хувь буюу 54 нь бүтэн өнчин, 92.9 хувь буюу 710 нь хагас өнчин хүүхдүүд байна.

### Хоёр. АЖИЛЛАХ ХҮЧ

2012 онд хөдөлмөрийн насны (15.түүнээс дээш нас) хүн амын тоо 40 314, үүнээс эдийн засгийн идэвхитэй хүн ам (ЭЗИХА)-ын тоо 24 428 болжээ. Өмнөх онтой харьцуулбал хөдөлмөрийн насны хүн амын тоо 2.9 хувь, эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 5.7 хувь мөн 2008 онтой харьцуулбал хөдөлмөрийн насны хүн амын тоо 9,5 хувь, эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 17,5 хувиар тус тус өсчээ.

Хүйсийн хувьд эдийн засгийн идэвхтэй хүн амын 53,4 хувь нь буюу 13 039 эрэгтэйчүүд байгаа нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн идэвхээс 6,8 пунктээр илүү гарчээ. Эдийн засгийн идэвхитэй хүн амыг сумаар авч үзвэл хамгийн өндөр нь Сайншанд ( 7358), Замын үүд (6385) сум байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 60,6 байгаа нь өмнөх оноос 1,6, 2008 оноос 4,1 пунктээр тус тус өсчээ.

**Зураг: Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр, оноор**



#### 1. Ажил эрхэлдэг хүн ам

Эдийн засгийн идэвхитэй хүн амын 96.3 хувь буюу 23 524 хүн ажил эрхэлж байгаа нь өмнөх оноос 0,5 пунктээр, 2008 оноос 2,1 пунктээр тус тус буурчээ.


Ажил эрхэлж байгаа хүн амын 29.8 хувь (7001) нь хөдөө аж ахуйн салбарт, 11.6 хувь (2733) нь бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээний салбарт, 22.8 хувь (5380) нь төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал, боловсрол, эрүүл мэндийн салбарт, 9.8 хувь (2299) нь тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбарт, 6.9 хувь (1630) нь уул уурхай, олборлох, боловсруулах аж үйлдвэр, цахилгаан дулаан үйлдвэрлэлийн салбарт, 19.1 хувь (4481) нь бусад салбарт ажиллаж байна.

Зураг. Ажиллагчдын тоо салбарын ангиллаар, 2012 он



Засаг захиргааны бүртгэлд үндэслэсэн ажил эрхлэлтийн 2012 оны жилийн эцсийн тайлангаар 16.8 мянган хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй хүн байна гэсэн дүн гарчээ. Үүний 10,1 хувь буюу 1.7 мянган хүн хөдөлмөрийн чадваргүйн улмаас, 37.0 хувь буюу 6.2 мянган хүн суралцаж байгаагаас ажил эрхлээгүй, үлдэх 8.9 мянган хүний 14,9 хувь буюу 2.5 мянган хүн гэрийн ажилтай, өөрөө өвчтэй, хүүхэд, өндөр настан асардаг, гэр бүлийн хүний ажлын онцлог зэрэг шалтгаанаар ажил эрхлээгүй бол, 38,0 хувь буюу 6,4 мянган хүн бусад шалтгаанаар ажил эрхлээгүй байна.

Зураг: Хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй хүн ам/ шалтгаанаар/



## 2. Ажилгүй иргэд


Аймгийн Хөдөлмөрийн хэлтэст ажил идэвхитэй хайж байгаа 904 ажилгүй иргэн бүртгэлтэй байгаа нь 2011 оны жилийн эцсийнхээс 21.5 хувиар өссөн байна.

2012 онд 1782 хүн ажил хайж бүртгүүлсний 878 иргэн ажилд зуучлуулан орж, шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэний тоо өмнөх оноос 15.8 хувь, ажилд зуучлагдан орсон хүний тоо өмнөх оноос 18.9 хувиар тус тус буурсан байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн насны бүтцийг авч үзвэл 15-24 насны иргэд 20.5 хувийг, 25-34 насны иргэд 40.7 хувийг, 35-44 насны иргэд 21.9 хувийг, 45-60 насны иргэд 16.9 хувийг эзэлжээ.

Ажилгүй иргэдийн 44.7 хувь нь эмэгтэйчүүд 55.3 хувь нь эрэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 21.4 пунктээр буурчээ.

**Зураг. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэн, ажилд зуучлагдан орсон хүний тоо, 2008-2012 он**



Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 19.0 хувь нь дээд боловсролтой, 13.2 хувь нь тусгай дунд, техник мэргэжлийн дунд боловсролтой иргэд байгаа бол 67.8 хувийг бүрэн дундаас доош боловсролтой иргэд эзэлж байна. 2012 онд шинээр 1015 ажлын байр бий болгосны 70.7 хувь нь байнгын ажлын байр байна.

Шинээр бий болгосон ажлын байрны 20.4 хувийг төсвийн хөрөнгөөр, 42.4 хувийг байгууллага өөрийн хөрөнгөөр, 0.7 хувийг гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр, 36.5 хувийг зээлийн эх үүсвэрээр бий болгожээ.

Шинээр бий болсон ажлын байрыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар үзвэл уул уурхайн салбарт 23.3 хувь төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгалын салбарт 15.9 хувь, ХАА-н салбарт 15.3 хувь, зам тээврийн салбарт 10.7 хувь барилгын салбарт 7.1 хувь, боловсрол, соёл урлагийн салбарт 3.3 хувь, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарт 1.6 хувь бусад салбарт 22.8 хувь ногдож байна.


## **Гурав. ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ**

### **1. Хөдөө аж ахуй**

2012 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 1327.9 мянган толгой мал тоологдсоны дотор 31.4 мянган тэмээ, 95.6 мянган адуу, 50.3 мянган үхэр, 531.5 мянган хонь, 619.1 мянган ямаа тоологджээ. Нийт малын тоо өмнөх оноос 10.0 хувь буюу 120.5 мянган толгойгоор өсчээ. Мал сүргийн тоо таван төрөл дээрээ өссөний дотор тэмээ 4.8 хувь, адуу 10.5 хувь, үхэр 10.3 хувь, хонь 11.4 хувь, ямаа 9.0 хувиар өсөв.

Жил бүрийн эцсийн мал тооллогын дүнг харахад аймаг байгуулагдсан 1931 оноос хойш 1939 онд 1385.6 мянга, 1940 онд 1335.3 мянган мал тоолуулж байсан бол энэ онд хамгийн олон мал тоолуулсан 3 дах он боллоо. Мөн мал сүргийг жилийн эцэст тоолдог болсон 1961 оноос хойш хамгийн олон мал тоологдсон жил байлаа.

**Зураг . Нэг саяас дээш толгой мал тоолуулсан он, малын тоо, мянган.толгой**




Сүргийн бүтцэд ямаа 46.6 хувийг, хонь 40.0 хувийг, үхэр 3.8 хувийг, адуу 7.2 хувийг, тэмээ 2.4 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад ямааны эзлэх хувь 0.4 тэмээний эзлэх хувь 0.1 пунктээр буурч, бусад 3 төрөл дээр 0.01-0.5 пунктээр нэмэгдэж, мал сүргийн бүтцэд ямаа ихэнх хувийг эзэлсэн хэвээр байна. Айраг, Алтанширээ, Эрдэнэ, Замын-Үүдээс бусад сумын мал таван төрөл дээрээ өссөн байна.

Аймгийн хэмжээгээр 1000–аас дээш малтай малчин өрхийн тоо 158 болж өмнөх оноос 52 өрхөөр нэмэгджээ. 1000 –аас дээш малтай өрх Дэлгэрэх суманд 24, Өргөн суманд 16, Иххэт суманд 15, Даланжаргалан суманд 14 тоологдсон нь хамгийн олон нь байсан бол 2000-3000 малтай өрх Замын-Үүд, Сайншанд, Иххэт, Өргөн, Дэлгэрэх сумдад тус бүр 1 өрх тоологджээ.

Аминдаа малтай 4593 өрх байгаагийн 77.3 хувь буюу 3552 нь жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж байгаа малчин өрх байна. Малчин нэг өрхөд 338, малтай нэг өрхөд 283 толгой мал ногдож байгаа нь 2011 оноос малчин нэг өрхөд ноогдох мал 31-ээр, малтай нэг өрхөд ногдох мал 24 толгой малаар нэмэгджээ.

2012 онд оны эхний хээлтэгч малын 76.9 хувь буюу 385.3 мянган эх мал төллөж, гарсан төлийн 99.7 хувь буюу 392.3 мянган төл бойжжээ. Үүнийг өмнөх онтой харьцуулахад төллөсөн хээлтэгч 1.0 хувиар, бойжсон төл 2.2 хувиар дутуу байна. Нийт төллөх насны эх малаас эм хонины 83.7 хувь, үнээний 78.0 хувь, эм ямааны 72.9 хувь, гүүний 68.6 хувь, ингэний 50.4 хувь нь төллөв. Эрдэнэ, Хатанбулаг суманд эх малын төллөлт хамгийн бага буюу 60.4-61.6 хувь байна.

**Зураг. Том малын зүй бусын хорогдол, мянган толгойгоор, 2000-2012 он**



2012 онд 12.2 мянган том мал зүй бусаар хорогдсон нь оны эхний малын 0.9 хувьтай тэнцэж байна. Эрдэнэ, Өргөн, Хатанбулаг, Мандах сумдад хорогдсон малын тоо нийт хорогдлын 61.0 хувийг эзэлж байна.

2012 онд тэжээвэр амьтан өсгөн үржүүлдэг өрхийн тоо 25 болж өмнөх оноос 16-аар буурчээ. 148 гахай, 578 шувуу тоологдсон нь өмнөх оноос тус бүр 1.7 дахин багассан байна. Тэжээвэр амьтад өсгөн үржүүлдэг өрхүүд 1.4 тонн гахайн мах бэлтгэж, 11.7 сая төгрөгийн борлуулалт, мөн 11.5 мянган ширхэг өндөг бэлтгэж 3.2 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

3 жил тутамд явагддаг хашаа худгийн тооллогын дүнгээр 2012 оны эцэст 2269 худаг тоологдсоноос инженерийн хийцтэй худаг 183, энгийн уурхайн худаг 2063 байна. Бэлчээрт байршдаг худаг 2143, ашиглагдахгүй байгаа худаг 17, усан сан 2 тоологдсоныг өмнөх тооллогын дүнтэй харьцуулж үзвэл нийт худгийн тоо 24 өөр буурчээ. Энэ онд 61 худаг шинээр гаргахад 512.4 сая төгрөг зарцуулсны 40.6 хувийг улсын төсвийн хөрөнгөөр, 48.4 хувийг малчдын хамтын хөрөнгөөр, 11.0 хувийг олон улсын төсөл хөтөлбөр, бусад эх үүсвэрээс санхүүжүүлжээ. Шинээр гаргасан худгийн тоо өмнөх оныхоос 5-аар буурав. 413 худаг сэргээн засварласны 402 нь энгийн уурхайн, 11 нь инженерийн хийцтэй бөгөөд худгийн засвар шинэчлэлтэд нийт 88.2 сая төгрөг зарцуулав. Үүний 41.4 хувийг малчид иргэдийн хөрөнгөөр, 56.2 хувийг гадаадын болон олон улсын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр засварласан байна.

2012 онд нийт 1956.9 мянган толгой малын багтаамж бүхий 3442 хашаа тоологдсоноос дулаан байртай 22, саравчтай хашаа 1581, саравчгүй хашаа 1702, бодын хашаа 137 тоологджээ. Өмнөх тооллого буюу 2009 оны тооллогын дүнгээс нийт хашааны тоо 1061-ээр нэмэгдсэн байна.

Малжуулах арга хэмжээнд 151 өрхийг хамруулж нийт 6812 толгой мал олгосны 98.3 хувь нь бог мал байв. Малжуулалтанд хамрагдсан өрхийн тоо өмнөх оныхоос 10 өрхөөр нэмэгдэж, нэг өрхөд дундажаар 45 толгой мал ногдож байгаа нь өмнөх оныхоос 2 толгойгоор илүү байна. Малжуулалтанд нийт 280.9 сая төгрөг зарцуулсны 30.3 хувийг гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр, 10.0 хувийг орон нутгийн хөрөнгөөр, 59.6 хувийг бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

Нийт малчин өрхийн 78.5 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 70.3 хувь нь телевизиртэй, 43.8 хувь нь автомашинтай, 49.1 хувь нь мотоциклтой мөн 78.8 хувь гар утас ашигладаг дүн гарчээ. Өмнөх оныхоос цахилгааны эх үүсгүүртэй өрх 5.6 хувиар буурч, телевизортой өрх 13.1 хувиар, автомашинтай өрх 19.2 хувиар, мотоциклтой өрхийн тоо 4.0 хувиар нэмэгджээ.


2012 онд 46.7 га талбайд төмс, 35.6 га-д хүнсний ногоо тариалж, 199.5 тн төмс, 159.4 тн хүнсний ногоо хураан авлаа. Өмнөх оныхоос хураан авсан төмс 25.7 тн-оор бага, хүнсний ногоо 9.3 тн-оор илүү байна. 1 га-аас 4.3-4.5 тонн төмс, хүнсний ногоо хураан авсан нь 2011 оноос төмс 0.2 тн нэмэгдэж, хүнсний ногоо 1.5 тн-оор багассан байна. Тайлант онд 1591.4 тн өвс хадлан 132.5 тн гар тэжээл, 206.0 тн хужир шүү болон бусад тэжээл бэлтгэсэн мэдээ ирүүлснийг өмнөх онтой харьцуулахад бэлтгэсэн өвс 14.1 хувиар, гар тэжээл 35.8 хувиар нэмэгдэв.

## **2. Аж үйлдвэр**


Аж үйлдвэрийн салбарт оны үнээр 11.6 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 18.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг дотоод, гадаад зах зээлд борлууллаа. Нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт өмнөх оноос 3 дахин, 2008 оноос 6 дахин, бүтээгдэхүүн борлуулалтын орлого өмнөх оноос 4 дахин, 2008 оноос 5 дахин тус тус нэмэгдсэн байна. Энэ өсөлтөнд нүүрсний олборлолт өмнөх оноос 31 дахин, 2008 оноос 29 дахин нэмэгдсэн нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 3.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 42.6 хувиар, 2008 оноос 2 дахин нэмэгдлээ.

**Зураг . Нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, оны үнээр, зэрэгцүүлэх үнээр, сая төгрөг**



**Зураг. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн бүтэц, хувиар, аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр**




Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 26.7 хувийг төрийн өмчийн байгууллага, 73.3 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэсэн байна. Хувийн өмчийн аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийг 2011 онтой харьцуулбал 56.7 пунктээр, 2008 онтой харьцуулбал 48,6 пунктээр нэмэгджээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл 2011 онд нийт үйлдвэрлэлийн 83.4 хувийг УҮГ үйлдвэрлэж байсан бол 2012 онд 70.5 хувийг компани, 26.7 хувийг улсын үйлдвэрийн газар, 2.4 хувийг өрхийн аж ахуй, 0.4 хувийг хоршоо, тус тус үйлдвэрлэжээ. Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн 19 бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс нүүрс 31 дахин, савласан цэвэр ус 7 дахин, жижиг төмөр эдлэл 3 дахин, оёдол 68.7 хувь, дээл 35.7 хувь, блок 50.9, талх 29.9, зайрмаг 29.6, нарийн боов 18.0 хувь, дулаан 16.4 хувь, цахилгаан 1.3 хувь хувиар тус тус өсчээ.

Үйлдвэрлэлийг аж үйлдвэрийн дэд салбараар нь ангилж үзвэл уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл 68.7 хувь, цахилгаан, хий, усан хангамжийн үйлдвэрлэл 26.7 хувь, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.5 хувь, боловсруулах салбарын бусад үйлдвэрлэл 2.1 хувийг тус тус эзэлж байна.


**Зураг. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт 2008-2012, оны үнээр, сая төгрөг**




**3.Барилга угсралт, их засвар**

2012 онд 110 гаруй объектод нийт 28050.8 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 3.6 хувиар, 2008 онтой харьцуулахад 77.7 хувиар өсчээ. Нийт хөрөнгө оруулалтын 15.1 хувийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, 15.2 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх 69.7 хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эзлэх хувь өмнөх оноос 3.1 пунктээр буурч, орон нутгийн хөрөнгө оруулалтын эзлэх хувь 3.0 пунктээр нэмэгдэж, 2008 онтой харьцуулахад улсын төсвийн хөрөнгө оруулалтын эзлэх хувь 10,8 пункт, орон нутгийн хөрөнгө оруулалтын эзлэх хувь 8,6 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

**Зураг. Барилга угсралт, их засварын ажил, мян.төг**




**Зураг. Барилга угсралт, их засварын ажил, санхүүжилтийн эх үүсвэрээр**



2012 онд нийт 15.8 тэрбум төгрөгийн үндсэн фондыг ашиглалтанд оруулсны 11.3 хувийг улсын төсвийн, 29.9 хувийг орон нутгийн төсвийн, 5.4 хувийг замын сангийн хөрөнгө оруулалтаар, үлдэх

хувийг бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ. Шинэ барилга шинэчлэлтэнд 26.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулсны 29.5 хувийг улсын болон орон нутгийн, 7.5 хувийг замын сангийн хөрөнгө оруулалтаар, 63.0 хувийг бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

**Зураг . Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэгчдийн бүтэц**



Нийт барилга угсралт, их засварын ажлын 23.8 хувийг аймгийн харьяа барилгын гүйцэтгэгч байгууллагууд гүйцэтгэснийг 2011 онтой харьцуулахад 5.9 пунктээр, 2008 онтой харьцуулахад 9,7 пунктээр нэмэгдсэн үзүүлэлт гарчээ.

2012 онд Айраг суманд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 737.1 сая төгрөгийн үндсэн фонд бүхий 150

хүүхдийн цэцэрлэг, Өргөн суманд орон нутгийн төсвийн хөрөнгө оруултаар 410.0 сая төгрөгийн үндсэн фонд бүхий ЗДТГ-ын барилга, Сайхандулаан суманд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 269.8 сая төгрөгийн үндсэн фонд бүхий 50 хүүхдийн цэцэрлэг, 329.7 сая төгрөгийн үндсэн фонд бүхий 50 ортой дотуур байр, Сайншанд суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1115.8 сая төгрөгийн үндсэн фонд бүхий Ёс заншил, өв соёл, хүндэтгэлийн ордон, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1997.0 сай төгрөгийн үндсэн фонд бүхий 920 хүүхдийн сургууль, 258.5 сая төгрөгийн үндсэн фонд бүхий дүүжин гүүр, замын сангийн хөрөнгө оруулалтаар 254.4 сая төгрөгийн үндсэн фонд бүхий Цагаан элсний 10 км зам, 425.0 сая төгрөгийн үндсэн фонд бүхий ганзамчдын гудамжны 3 км зам, хувийн хөрөнгө оруулалтаар 244.0 сая төгрөгийн үндсэн фонд бүхий үйлчилгээний төвийн барилга, 984 сая төгрөгийн үндсэн фонд бүхий 30 айлын орон сууц, 500.0 сая төгрөгийн үндсэн фонд бүхий 5 айлын 2 орон сууцны барилга, Замын-Үүд суманд хувийн хөрөнгө оруулалтаар 2500.0 сая төгрөгийн үндсэн фонд бүхий төрийн албан хаагчдын орон сууц, 2000.0 сая төгрөгийн үндсэн фонд бүхий 70 айлын орон сууц, 500.0 сая төгрөгийн үндсэн фонд бүхий үйлчилгээний төвийн барилга зэрэг 36 обьктыг ашиглалтанд хүлээлгэн өгчээ.

**4.Тээвэр, Холбоо**

2012 онд 133.8 мянган тонн ачаа тээвэрлэж, 32240 .0 мянган тонн км-ын ажил, 94.6 мянган зорчигч тээвэрлэж 3653.2 мянган хүн км-ын ажил гүйцэтгэсэн байна. Тээвэрлэлтийн нийт орлого 2467.0 сая төгрөгт хүрсэн нь 2008 оноос 7.8 дахин, өмнөх оноос 2 дахин өсчээ.

2012 онд хийгдсэн тээврийн хэрэгслийн техникийн хяналт оношлогооны мэдээгээр 10501 авто машин, тээврийн хэрэгсэл хамрагдсан нь өмнөх оноос 26.1 хувь буюу 2174-оор нэмэгджээ. Нийт тээврийн хэрэгслийн 43.5 хувийг суудлын, 21.7 хувийг ачааны автомашин, 3.4 хувийг автобус, 6.6 хувийг мотоцикл, 10.8 хувийг тусгай зориулалтын автомашин, 12.9 хувийг чиргүүл, 1.0 хувийг бусад механизмууд эзэлж байна. Нийт тээврийн хэрэгслийн 70.0 хувь нь иргэдийн хувийн өмчид харьяалагдаж байна. Харин 2012 оны жилийн эцсийн мал тооллогоор малчин өрхүүдэд тоологдсон мотоциклын тоог техникийн хяналт оношлогооны дүнтэй харьцуулж үзэхэд аймгийн хэмжээний 10 мотоциклийн 4 нь хяналт оношлогоонд хамрагдаагүй дүн гарчээ.

Шуудан холбооны үйлчилгээний орлого 346.5 сая төгрөг болж 2008 оноос 18.8 хувиар буурч, харин өмнөх оноос 15.0 хувиар өссөн байна. Суурин телефон цэгийн тоо 2008 оноос 58.0 хувь буюу 1199–оор, өмнөх оноос 7.1 хувиар буюу 66–аар буурчээ. Энэ онд нийт 9.9 мянган ширхэг албан

бичиг, захидал, 356 ширхэг илгээмж (боодол) илгээсэн бол шуудангаар 1599 зорчигч үйлчлүүлж 19.6 сая төгрөгийн орлого оруулжээ.

Аймгийн хэмжээнд 5 кабелийн телевиз үйлчилгээ үзүүлж нийт 205.9 сая төгрөгийн орлого оруулж, 4000 гаруй хэрэглэгчдэд үйлчилж байна. Байршлаар нь авч үзвэл Сайнашанд суманд 3, Замын-Үүд суманд 1, Өргөн суманд 1 кабелийн телевизийн цэг ажиллаж байна.

2012 онд Дорноговь аймагт үүрэн телефоны оператор 5 компанийн салбар ажиллаж байгааг байршлаар авч үзвэл юнителын 15, мобикомын 13, скайтелын 12, G-mobile 10, F-zoni 2 нийт 60 салбар нэгж сум, суурин газруудад үйлчилгээ үзүүлжээ. Үүрэн телефоны салбарууд энэ онд нийт 3677.9 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өмнөх оныхоос 8.4 хувиар нэмэгдсэн ба 2008 онтой харьцуулвал 2 дахин өсчээ. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (давхардсан тоогоор) 63.1 мянга орчим байгаа нь өмнөх оноос 17.9 мянгаар, 2008 оноос 36.6 мянган хэрэглэгчээр нэмэгджээ.

### 5. Орон сууц, нийтийн аж ахуй, дотоод худалдаа

2012 онд нийт 25.2 мян.м<sup>2</sup> талбай бүхий орон сууцыг шинээр ашиглалтанд оруулсанаар 212 өрх, 873 хүн шинэ сууцаар хангагджээ. Ашиглалтанд оруулсан орон сууцны талбайг 2011 онтой харьцуулбал 74,7 хувиар, 2008 оноос 4 дахин нэмэгдсэн байна.

Хот, нийтийн аж ахуйн үзүүлэлтийг 2010 оноос өмнөх онуудад зөвхөн сумын төв, суурин газруудын мэдээллээр харуулдаг байсан бол 2010 оноос аймгийн дүнгээр мэдээлдэг боллоо.

2012 онд гүний худаг 470, ус түгээх цэг 60, цэцэрлэгт хүрээлэн 19, хөшөө баримал 61, гэрэлтүүлэгтэй гудамж талбай 48 км болжээ.


Өмнөх оноос халуун усны газар 3-аар, хог тээврийн машины тоо 11.1 хувиар буурсан байна.

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын орлого 65181.1 сая төгрөгт хүрч өмнөх оноос 0.2 хувиар буурсан байна. Өмнөх оноос буурсан шалтгаан нь НИК ХК-ны салбар нь 3 том уурхайд шатахуун нийлүүлж байгаад больсонтой холбоотой байна.

### 6.Боловсрол

2012/2013 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 21 сургуульд 10869, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ЭМШУИС-ийн салбар сургуульд 1869 бүгд 12738 оюутан, сурагч суралцаж байна. Энэ нь өмнөх оноос 1.0 хувиар, 2008 оноос 2.5 хувиар буурчээ.

**Зураг. Бүх шатны сургуульд суралцагсад, элсэгчид, төгсөгчид, хичээлийн жилд**



2012/2013 оны хичээлийн жилд ЕБС-ийн 388 бүлэгт 10869 сурагч суралцаж, 555 багш ажиллаж, нэг багшид ногдох хүүхдийн тоо 20 болж өнгөрсөн хичээлийн жилийнхээ түвшнээс 1-ээр, 2008 оноос 2-оор буурлаа. Бага боловсролын 209 бүлэгт 5666 сурагч, суурь боловсролын 120 бүлэгт 3325

сурагч, бүрэн дунд боловсролын 59 бүлэгт 1878 сурагч суралцав. Нийт бүлгээс 1-р ээлжинд 67.8 хувь, 2-р ээлжинд 28.6 хувь, 3-р ээлжинд 3.6 хувь нь хичээллэж байна.

ЕБС-ийг бага, суурь, бүрэн дунд боловсролоор 3601 сурагч төгсчээ. Сурагчдын сурлагын стандарт хангалт 96,8 хувь, А,В-ийн эзлэх хувь 45.4 хувь байгаа нь өмнөх онтой харьцуулбал 0.2-5.6 пунктээр, 2008 оноос 0.5-3.9 пунктээр нэмэгджээ.

ЕБС-ийн нэгдүгээр ангид 2012/2013 оны хичээлийн жилд 1157 хүүхэд шинээр элсэв.

2012/2013 оны хичээлийн жилд сургууль завсардсан 6-14 насны 23 хүүхэд нь нийт суралцагчдын 0.2 хувийг эзэлж, 2011/2012 оны хичээлийн жилээс 4.5 хувиар нэмэгдсэн байна.

ЭМШУИС-ийн салбар сургуульд 255 оюутан элсэн орсны 24.3 хувь буюу 62 оюутан анагаах, сувилахуй /баклавар/ болон бусад дээд мэргэжлээр, 75.7 хувь буюу 193 оюутан эм найруулагч, бага эмч мэргэжлээр элссэн.

МСҮТ-д 10 мэргэжлээр 459 хүүхэд шинээр элсүүлж, 856 оюутан суралцагчтайгаар хичээллэжээ.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 2012/2013 оны хичээлийн жилд 3.6 мянган хүүхэд хамрагдсан нь 2010/2011 оны хичээлийн жилээс 17.3 хувиар, 2011/2012 оны хичээлийн жилээс 5.8 хувиар нэмэгдсэн байна.

## **7.Соёл, эрүүл мэнд**

Дорноговь аймгийн хүн амын эрүүл мэндийн үйлчилгээнд эрүүл мэндийн бүх шатны 94 байгууллагад нийт 925 хүн ажиллаж байгаа нь 2008 оноос 11.4 хувиар, 2011 оноос 3.5 хувиар нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн байгууллагын ажилчдын 19.8 хувь буюу 183 нь их эмч, 19.2 хувь буюу 178 нь сувилагч байна.

Нэг их эмчид ногдох хүний тоо 2012 онд 333 байгаа нь өмнөх оноос 5-аар буурч, 2008 онтой адил болж, нэг сувилагчид ногдох хүний тоо 342 болж өмнөх оноос 6-аар, 2008 оноос 26-аар нэмэгдлээ.

2012 онд эмнэлэгийн орны тоо 366 болж 5-аар нэмэгджээ. 13.3 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсний 46.7 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 6.5 хувь нь хувийн өмчийн эмнэлэгүүдэд хэвтэж эмчлүүлжээ.

Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэлх насандаа 14.5 хүүхэд эндсэн нь өмнөх оны мөн үеэс 2.7 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. 404,6 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өсч, 13.3 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 2.2 хувиар буурчээ.

Дээрхи үзүүлэлтийг 2008 онтой харьцуулбал 1 хүртэлх насандаа эндсэн хүүхэд 0.5 пунктээр, амбулаторын үзлэг 15.8 хувиар, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүний тоо 1.3 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Халдварт өвчнөөр 1014 хүн өвчилж халдварт өвчний гаралт өмнөх оны мөн үеэс 17.3 хувиар буурлаа. Үүний дотор вируст гепатит 69.4 хувь, сүрьеэ 26.8 хувиар буурсан бол тэмбүү 13.3 хувь, заг хүйтэн 14.1 хувь, трихоминиаз 12.4 хувиар нэмэгджээ.

Он гарсаар 1684 эх жирэмсэний хяналтанд орсон нь өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар буурсан байна. Жирэмсний хяналтанд орсон эхчүүдийн 86.5 хувь нь эхний 3-н сартайдаа хяналтанд хамрагдав. Өөрөөр хэлбэл 13.5 хувь нь хугацаанаасаа хожимдож эмнэлгийн хяналтанд оржээ. Түргэн тусламжийн 21.9 мянган дуудлага ирсний 15,4 хувь нь алсын дуудлага байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 3.8 хувиар, алсын дуудлага 5.5 хувиар өсөв.

## 8.Нийгмийн даатгал, халамж

2012 онд нийгмийн даатгалын сангийн нийт орлого 16837.4 сая төгрөг, олгосон тэтгэвэр 14182.2 сая төгрөгт хүрч өмнөх оноос 32,4-73.4 хувиар нэмэгдлээ. Нийгмийн даатгалд заавал даатгуулагч байгууллагын 52.0 хувь буюу 8683 нь аж ахуйн нэгж байгууллага, 48.0 хувь буюу 8016 нь төсөвт байгууллага байгааг өмнөх онтой харьцуулахад 10.0-14.0 хувиар өссөн байна.

Тэтгэвэрийн даатгалын сангаас 13859,1 сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 3912,8 сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 1221,3 сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 1055,1 сая.төг ажилгүйдлийн даатгалын сангаас 691,2 сая.төгрөгийг тэтгэвэр тэтгэмж, даатгалд зарцуулсан байна.

### *Зураг. Нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо, ААНБ-ын төрлөөр*



2012 онд нийгмийн халамжийн сангаас 8.4 мянган иргэнд 2939.6 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгожээ.

Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй 1837 эхэд 705.7 сая.төг, алдар цолтой 59 ахмадад 71.9 сая.төг, алдарт эхийн одонтой 4678 эхэд 642.1 сая.төгрөгийн тэтгэмж, тусламжийг улсын төсвөөс олгосон байна. Ахмад настны нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэний тоо өмнөх оны мөн үеэс 14.3 хувиар буурчээ.

“Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд хувь хишиг хүртээх тухай” УИХ-ын тогтоолын дагуу 2012 онд 65.8 мянган иргэнд 13936.8 сая.төг-ийн хишиг хүртээжээ.

## **ТАВ. ТӨСӨВ, МӨНГӨН ГҮЙЛГЭЭ, ҮНЭ**

### **1. Төсөв**

2012 оны урьдчилсан дүнгээр орон нутгийн төсөвт 19385.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 113.3 хувиар биелүүлжээ. Орон нутгийн төсвийн орлогын 70.5 хувийг татварын, 4.3 хувийг татварын бус орлого, 20.0 хувийг хөрөнгийн орлого, 5.2 хувийг тусламжийн орлого бүрдүүлсэн байна. Өмнөх онтой харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 47.1 хувь, зарлага 29.9 хувь, 2008 онтой харьцуулахад 2.7 дахин, зарлага 2.2 дахин нэмэгдсэн байна.

Улсын төсвийн байгууллагуудын 27835.7 сая төгрөгийн зарлагыг санхүүжүүлсний дотор цалин хөлс ба нэмэгдэл урамшилд 60.4 хувийг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 5.9

хувийг, бараа үйлчилгээний бусад зардалд 26.4 хувийг, татаас ба урсгал шилжүүлэг 7.3 хувийг тус тус санхүүжүүлжээ.

Улсын төсвийн зарлагын 88.6 хувийг улсын төсвийн санхүүжилтээр, 4.4 хувийг эрүүл мэндийн даатгал, 7.0 хувийг өөрийн орлогоос тус тус санхүүжүүлжээ.


Улсын нэгдсэн төсөвт ААНБОАТатвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, онцгой албан татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, өсөн нэмэгдэх ашигт малтмалын татвар нийт 1938.0 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 120.0 хувиар биелүүллээ. Өмнөх онтой харьцуулахад 26.2 хувиар өсч, 2008 онтой харьцуулахад 36.5 хувиар буурсан байна. 2008 оноос 36.5 хувь буурсан нь цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын албан татвар орон нутгийн төсвийн орлогод шилжсэнтэй холбоотой байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Мандах, Улаанбадрах, Эрдэнэ, Сайншанд сумд 101.4-117.6 хувиар биелүүлэв.

## 2. Банк, мөнгө, зээл


Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 366.7 тэрбум төгрөг болж өмнөх оноос 42.4 хувь, цэвэр зарлага 362.0 тэрбум төгрөг болж 39.2 хувь, 2008 онтой харьцуулахад кассын орлого 2 дахин, цэвэр зарлага 2.1 дахин өсчээ. Цэвэр орлого нь зарлагаас 1.3 хувиар их байна. Мөн салбар нэгжийн тоо өмнөх онтой харьцуулбал 15.8 хувиар нэмэгдсэн байна.

**Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2009- 2012 он, мян.хүн**



Иргэдийн мөнгөн хадгаламж 26.3 тэрбум төгрөг болж аймгийн нэг хүнд дундажаар 431.2 мянган төгрөгийн, нэг хадгаламж эзэмшигчид дундажаар 675.2 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 22.9 хувь, 2008 онтой харьцуулахад 75.2 хувь, хадгаламжийн үлдэгдэл 40.8 хувь, 2008 онтой харьцуулахад 3,6 дахин өсчээ.

**Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2009-2012 он, сая.төг**



Олгосон зээлийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 26.2 хувиар буурч, 2008 онтой харьцуулахад 2.4 хувиар өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн өрийн үлдэгдэл 26.5 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 30.9 хувь, зээлийн багцад чанаргүй зээлийн эзлэх хувь 0.01 пунктээр өсөв.

Төгрөгийн зээлийн жилийн дундаж хүү өмнөх онтой харьцуулахад Голомт банкинд 2.0 хувь, Хаан банкинд 4.5 хувиар өсч, Хадгаламж банк 2.2 хувиар буурч, Хас, ХХБанкууд хэвэндээ байна. 2008 онтой харьцуулахад Голомт, Хаан, Хадгаламж банкууд 5.4-7.4 хувиар буурч, Хас банк 0.5 хувиар өсч, ХХБанк хэвэндээ байна.

### 3. Үнэ

Хэрэглээний үнийн индекс 2012 онд суурь үнээс (2010 оны 12-р сар) 23.7, 2011 оны жилийн эцсээс 13.8 хувиар, өмнөх сараас 1.4 хувиар өсчээ.

Хүснэгт: Хэрэглээний үнийн индекс, бүлгээр, оны эцэст

Бараа, үйлчилгээний бүлэг	ЖИН	2012 - 12	2012-12	2012- 12
		2010- 12	2011-12	2012-11
<b>ЕРӨНХИЙ ИНДЕКС</b>	<b>1.00000</b>	<b>123.7</b>	<b>113.8</b>	<b>101.4</b>
ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	<b>0.337093</b>	137.5	118.2	102.8
СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ	<b>0.025451</b>	<b>161.8</b>	<b>156.4</b>	<b>100.0</b>
ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	<b>0.179869</b>	<b>125.4</b>	<b>116.1</b>	<b>101.3</b>
ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ТҮЛШ	<b>0.096042</b>	<b>114.5</b>	<b>109.4</b>	<b>100.0</b>
ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	<b>0.061688</b>	<b>109.3</b>	<b>109.6</b>	<b>100.1</b>
ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	<b>0.016436</b>	<b>117.5</b>	<b>116.9</b>	<b>100.0</b>
ТЭЭВЭР	<b>0.143338</b>	<b>104.9</b>	<b>101.6</b>	<b>100.0</b>
ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	<b>0.048637</b>	<b>100.8</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	<b>0.020528</b>	<b>96.6</b>	<b>94.6</b>	<b>100.0</b>
БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	<b>0.001547</b>	<b>142.9</b>	<b>129.9</b>	<b>100.0</b>
ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	<b>0.007548</b>	<b>170.5</b>	<b>152.9</b>	<b>100.0</b>
БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	<b>0.039281</b>	<b>112.7</b>	<b>108.1</b>	<b>100.0</b>

**Ерөнхий индекс өмнөх сарынхаас 1.4 хувь** өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 2.8 хувь, хувцас, бөс бараа, гуталын бүлэг 1.3 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 0.1 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс өмнөх сарынхаас 1.4 хувь өсөхөд эмэгтэй хувцас 9.8-23.4 хувь, мон лаа 8.3 хувь, махны үнэ 6.4-10.0 хувь өссөн нь голлон нөлөөлжээ. Харин согтууруулах ундаа, тамхи, орон сууц, цахилгаан, түлш, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ, тээвэр, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг, амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ, боловсролын үйлчилгээ, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ, бусад бараа, үйлчилгээний бүлэгүүд тогтвортой байна. (Хүснэгт1)

**Өмнөх оны мөн үеийнхээс (2011 оны 12-р сар) 13.8 хувь** өсөхөд зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлэг 52.9 хувь, согтууруулах ундаа, тамхи бүлэг 56.4 хувь, боловсролын бүлэг 29.9 хувь, хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн дүн 18.2, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 16.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 9.4 хувиар тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. (Хүснэгт1)


Хэрэглээний үнийн индекс өмнөх оны мөн үеийнхээс 13.8 хувь өсөхөд 1 шуудай түлшний мод 85.7 хувь, тамхи 84.6 хувь, зочид буудлын хөлс 47.6 хувь, Ерөөл архи 45.0 хувь, махны үнэ 33.3-58.0 хувь, орон нутаг дахь улсын их дээд сургуулийн жилийн төлбөр 29.9 хувь өссөн нь голлон нөлөөлжээ.

**Хэрэглээний үнийн индекс 2012 онд өмнөх оны 12 сартай харьцуулсан** индексээс харахад хамгийн өндөр өсөлттэй сар нь 7-р сард 114.7 хувьд хүрсэн байна. Энэ сарын өсөлтөд зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлэг 42,8 хувь, хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 29,3 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 15.6 хувь, хувцас бөс бараа, гутал бүлэг 12,4 хувь тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Мөн оны 5-12 дугаар сард үнийн индекс 112.0 хувиас буурсангүй. Харин хамгийн бага өсөлттэй сар нь 1-4 сар байна.

**Хэрэглээний үнийн индекс суурь үнээс (2010 оны 12-р сар) 23.7 хувь** өсөхөд зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 70.5 хувь согтууруулах ундаа, тамхины бүлэг 61.8 хувь, боловсролынх 42.9 хувь, хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийнх 37.5 хувь, хувцас бөс бараа, гуталийнх 25.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийнх 14.5 хувь өссөн нь нөлөөлжээ. (Хүснэгт2)

Хэрэглээний үнийн индекс суурь үнээс 23.7 хувь өсөхөд малын мах, янжуур тамхи, зочид буудлын хөлс 2.7 - 2.9 дахин, эх орны үйлдвэрийн туузан гоймон 2.2 дахин, унадаг дугуй 97.8 хувь, 1 шуудай түлшний модны үнэ 85.7 хувь, хог хаягдалын өрхийн сарын хөлс 67.0 хувь, орон нутаг дахь улсын их дээд сургуулийн жилийн төлбөр 45.6 хувь, архи 45.0 хувь өссөн нь голлон нөлөөлжээ.

**Зураг. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын индекс, 2010 - 2012 оны сар бүрээр (өмнөх оны 12-р сар=100)**



### **ЗУРГАА. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО**

Статистикийн бизнес регистрийн санд 2012 оны жилийн эцсийн байдлаар 905 аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагийн 607 буюу 67.1 хувь хэвийн үйл ажиллагаа явуулж 32.9 хувь нь үйл ажиллагаа эхлээгүй, түр зогссон, бүрэн зогсоосон болон бусад шалтгаанаар үйл ажиллагаа явуулаагүй байна. 2012 онд 106 аж ахуй нэгж шинээр байгуулагдаж, 75 аж ахуйн нэгж татан буугджээ.

Өмнөх онтой харьцуулахад бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо 6.8 хувиар, 2008 оноос 36,1 хувиар өссөн ч үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн эзлэх хувь өмнөх оноос 16.8 пунктээр, 2008 оноос 5,4 пунктээр буурчээ.

Нийт аж ахуйн нэгжийн 27.1 хувь нь худалдааны салбарт, 14.1 хувь нь санхүү, албан бус даатгалын салбарт, 12.9 хувь нь нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээний салбарт, 8.7 хувь нь зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагааны салбарт үйл ажиллагаа явуулж байна. Өмнөх оноос хөдөө аж ахуй, уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, зочид буудал, зоогийн газар, тээвэр, агуулах, санхүү, үл хөдлөх, боловсрол, эрүүл мэнд, нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйл ажиллагааны салбарын аж ахуйн нэгжийн тоо 1.9-50.0 хувиар өсч, бусад салбарынх 2.0-50.0 хувиар буурч, 2008 оноос хөдөө аж ахуй, уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, барилга, зочид буудал, зоогийн газар, тээвэр, агуулах, санхүү, үл хөдлөх, боловсрол, эрүүл мэнд, нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйл ажиллагааны салбарын аж ахуйн нэгжийн тоо 17.3 хувиас 3 дахин өсч, бусад салбарынх 40.0-98.0 хувиар буурчээ.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 75.9 хувийг 1-9 ажиллагчтай, 11.5 хувийг 10-19 ажиллагчтай, 9.2 хувийг 20-49 ажиллагчтай, 3.4 хувийг 50-с дээш ажиллагчтай аж ахуйн нэгж эзэлж байна. Өмнөх оноос аж ахуйн нэгж байгууллагын 1-9 ажиллагчтай 2.1 пунктээр, 50-с дээш ажиллагчтай 0,2 пунктээр нэмэгджээ.

Аймгийн хэмжээнд бүртгэлтэй нийт аж ахуйн нэгжийн 53.7 хувь нь Сайншанд суманд, 18.4 хувь нь Замын-үүд суманд бүртгэлтэй байна.

## **ДОЛОО. БУСАД**

### **1. Байгал орчны төлөв байдал**

Дорноговь аймгийн нийт газар нутгийн 88.5 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 9.0 хувийг улсын тусгай хэрэгцээний газар, 1.4 хувийг ойн сан бүхий газар, 0.4 хувийг хот, тосгон, суурин газар, 0.5 хувийг зам, шугам сүлжээний газар, 0.2 хувийг усан сан бүхий газар эзэлж байна.

2012 онд аймгийн нийт газар нутгийн 0.0075 хувь буюу 822.4 га газарт ямар нэг хэмжээний хохирол учруулжээ. 632.8 га газар ухагдаж эвдэрсэн ба үүний 66.5 хувь буюу 420.8 га газар геологийн эрэл хайгуулын ажлаас, 23.7 хувь буюу 150 га газар зам, тээвэр, холбооны барилга, засвар үйлчилгээнээс, 9.6 хувь буюу 60.6 га газар ашигт малтмалын олборлолтоос, 0.2 хувь буюу 1.4 нь барилга инженерийн шугам сүлжээ барих, засвар үйлчилгээний ажлаас шалтгаалсан байна.

131.35 га газарт нөхөн сэргээлтийн ажил хийсэн бөгөөд үүнд 809.4 сая төгрөгийн зардал гаргажээ. Аймгийн хэмжээнд 2012 онд 91.1 мянган ш мод тарьснаас 82.0 хувь нь ургасан байна. 2012 оны эцэст ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБайгууллагын тоо 4 дахин, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ-ын тоо 1.8 дахин нэмэгджээ.

Газар өмчлөх хүсэлт ирүүлсэн 3045 өрхийн газар өмчлүүлэх шийдвэр гаргасан ба гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэдэд өмчлүүлсэн газрын хэмжээ 629.76 га болж өмнөх оноос 3 дахин өслөө.

### **2. Цаг үүр**

2012 онд агаарын дундаж температурын 4,4 хэм дулаан буюу олон жилийн дунджаас -0.5 хэмээр сэрүүн, өмнөх оноос 0.2 хэмээр дулаан байлаа. Агаарын температур өдөртөө ихэнх нутгаар 6, 7, 8 дугаар саруудад 35-39 хэм хүрч халсан бол агаарын үнэмлэхүй хамгийн бага температур 1, 12 дугаар саруудад ихэнх нутгаар -27-38 хэм хүрч хүйтэрсэн байна. 2012 онд хөрсний гадаргын жилийн дундаж температур 6,7 хэм байж, өмнөх оноос 0.7 ° хүйтэн байжээ. Хөрсний гадаргын үнэмлэхүй хамгийн их температур 6, 7, 8 дугаар саруудад ихэнх нутгаар 61-67 хэм дулаан, хөрсний гадаргын үнэмлэхүй хамгийн бага температур 12, 1 дугаар сард нутгийн ихэнх хэсгээр -36-40 ° хүйтэн байлаа.

Жилдээ 60-127 өдөр шороон шуургатай байдгаас ихэнх нь буюу 65 хувь нь 3,4,5,6 дугаар сард ажиглагдаж энэ үеэр салхины хамгийн их хурд 16-30 м/с буюу аюулын хэмжээнд хүрч шороон болон цасан шуурга шуурчээ.

2012 оны байдлаар аймгийн нийт нутгаар олон жилийн дунджаас ахиу тунадас орсон байв. Энэ онд хур тунадас 1 дүгээр сард бага, 2, 4 дүгээр саруудад олон жилийн дунджын орчим орсон бол бусад саруудад тухайн сарынхаа олон жилийн дунджаас ахиу тунадас орсон байна. Нийт нутгаар хур тунадас 4-8 дугаар сарын хооронд олон жилийн дунджаас ахиу тунадас орсон нь ургамлын ургалтанд сайнаар нөлөөлж зуншлага хэвийн буюу сайн байв. 8 дугаар сарын ургацын мэдээгээр: аймгийн нийт нутгийн 4,6 хувь нь зуншлага маш сайн, 16,2 хувь нь зуншлага сайн, 79,2 хувь нь зуншлага хэвийн байлаа.


8 дугаар сарын 20-ны байдлаар Даланжаргалан сумын Бичигт баг, Айраг сумын Цагаандөрвөлж баг, Дэлгэрэх сумын Бумбат багийн нутгаар зуншлага маш сайн ба 9,0-11,6 ц/га ургацтай, Даланжаргалан, Айраг сумдын нийт нутаг, Иххэт сумын Бүрдэнэ, Баян баг, Дэлгэрэх сумын Цагаан хад, Аманшанд багууд, Алтанширээ сумын Тойг баг, Эрдэнэ сумын Цагаан хөтөл баг, Замын-үүд сумын I баг, Сайншанд сумын V багийн нутгаар зуншлага сайн буюу 4,3-7,9 ц/га ургацтай, бусад сум багийн нутгаар зуншлага хэвийн 0,7-4,3 ц/га ургацтай байв. Аймгийн нийт нутгаар бэлчээрийн хөнөөлт хортон шавьж ажиглагдсангүй.

### **3. “Тогтвортой амьжиргаа-II” төслийн хэрэгжилт**


“Тогтвортой амьжиргаа-II” төслийн зорилго нь эрүүл мэнд, боловсрол, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, байгаль цаг уурын эрсдэлд малчдын бэлэн байх чадварыг нэмэгдүүлэх, алслагдсан орон нутагт жижиг зээлийн үйлчилгээг хүргэх замаар амьжиргааг баталгаажуулах, тогтворжуулахад улсын хэмжээнд иргэдийн хэрэгцээ, оролцоонд тулгуурласан механизмыг бүрдүүлэхэд чиглэгдсэн болно. 2009-2012 онд нийт 1186,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий 148 төслийг хэрэгжүүлжээ.

Төслийн хүрээнд 2012 онд нийт 495.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж үүнээс 216.2 сая төгрөг буюу 43.6 хувийг бэлчээрийн МАА-н эрсдэлийг бууруулах чиглэлд, 139.8 саят төгрөг буюу 28.2 хувийг дэд бүтцийн салбарт, 67.9 сая төгрөг буюу 13.7 хувийг боловсролын, 46.0 сая төгрөг буюу 9.3 хувийг бусад салбарт 25.4 сая төгрөг буюу 5.2 хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулжээ. Бэлчээрийн мал аж ахуйн эрсдэлийн удирдлагын бүрэлдэхүүн хэсгийн үндсэн зорилт нь бэлчээрийн тохиолдож болох эрсдэлд бэлэн байж хариу өгөх үр ашигтай стратегийг өргөжүүлэн тархах ба нэвтрүүлэх явдал бөгөөд зорилтын хүрээнд 14 суманд 662,5 сая төгрөгийн өртөг бүхий 468 төсөл хэрэгжүүлсэн байна.

**Зураг. ОНССангийн хөрөнгө оруулалт төслийн чиглэл. 2009-2012 оны дүнд эзлэх хувь**



**Зураг. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр. 2009-2012 оны дүнд эзлэх хувь**




Энэхүү төслийн үр шимийг хүртсэн нийт давхардсан тоогоор 341286 хүний 182047 нь эмэгтэйчүүд, 38643 нь ядуу иргэд байна. Энэ хугацаанд 8 хүнийг байнгын 15 хүнийг улирлын чанартай ажлын байраар хангасан байна

**4.Гэмт хэрэг**

Аймгийн Цагдаагийн газрын мэдээгээр 2012 онд 582 гэмт хэрэг гарсан нь өмнөх оноос 36 буюу 6.6 хувиар, 2008 оноос 54 буюу 10.2 хувиар өсчээ. Өмнөх оны мөн үетэй хэргийн төрлийг харьцуулбал тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 32.9 хувиар, контарвантын гэмт хэрэг 31.0 хувиар, танхайн гэмт хэрэг 20.0 хувиар, ашиглангийн гэмт хэрэг 12.5 хувиар буурч, ИЭЧЭМ-ийн эсрэг гэмт хэрэг 6.3, өмчийн хулгайн гэмт хэрэг 11.9 хувиар, залилангийн гэмт хэрэг 28.6 хувиар, дээрэм 50.0 хувиар, хүний амь, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 2.1 дахин, бусдын эд зүйлийг булаах гэмт хэрэг 3 дахин өсчээ.

**Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар, 2012он**



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 37.8 хувийг ИЭЧЭМ эсрэг гэмт хэрэг, 24.2 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 8.1 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 3.4 хувийг танхай, 3.4 хувийг

контарвантын гэмт хэрэг, 3.3 хувийг хүний амь, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 2.2 хувийг хүчингийн гэмт хэргүүд эзэлж байна.

Өмнөх оны мөн үеэс Айраг, Улаанбадрах, Замын-Үүд суманд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо буурч, бусад сумдад гэмт хэргийн тоо өссөн үзүүлэлттэй байна.

Онц хүнд, хүнд төрлийн гэмт хэрэг 56 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 16 гэмт хэргээр буюу 40.0 хувиар, 2008 оноос 12 гэмт хэргээр буюу 27.3 хувиар нэмэгджээ.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 7628.0 сая төгрөгийн хохирол учирсан ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.9 дахин өссөн байна. Учирсан хохирлын 6.8 хувь нь эргэн төлөгджээ.

Нийт гэмт хэргийн 42.3 хувийг согтуугаар, 32.1 хувийг гэр орон сууцанд, 15.3 хувийг гудамж олон нийтийн газарт, 11.0 хувийг бүлэглэн, 59.1 хувийг шөнө, оройн цагаар үйлдсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 12.5 хувийг эмэгтэй хүн оролцон, 4.3 хувийг хүүхэд оролцон үйлдсэн нь өмнөх оны мөн үеэс 1.2-1.5 пунктээр нэмэгджээ. Бүлэглэн үйлдсэн, согтуугаар үйлдсэн гэмт хэргийн тоо 10.3-14.4 хувиар, гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо 93.8 хувиар өсч, гэмтэж бэртсэн хүний тоо 9.2 хувиар буурчээ. Тайлант хугацаанд нийт 3426 хүн эрүүлжүүлэгдэж, 334 хүн баривчлагджээ.

## **5.Бусад**

Аймгийн хэмжээнд 2012 онд их бага хэмжээний 23 гал түймэр гарч, 90.6 сая.төг-ийн хохирол учирч, гал түймрийн улмаас 4 хүний амь үрэгджээ. Гарсан гал түймрийн тоо 23.3 хувиар буурсан хэдий ч учирсан хохиролын тоо 2.3 дахин өсчээ.

Нийт гарсан гал түймрийн 21.7 хувь нь цахилгаан ашиглалтын буруугаас, 21.7 хувь нь хүүхдийн болгоомжгүй үйлдлээс, 17.4 хувь нь техникийн гэмтэл болон пийшин зуухны зөрчлөөс, 13.1 хувь нь архидан согтуурсан болон хүний санаатай үйлдлээс гарсан бол 26.1 хувийн шалтгаан тодорхойгүй байна.

Тайлант онд 622 аж ахуйн нэгж, байгууллага, 25564 айл өрхөд гал түймрээс урьдчилан сэргийлэх үзлэг явуулсан нь өмнөх оны мөн үеэс аж ахуйн нэгж, байгууллагын тоо 61.6 хувиар, айл өрхийн тоо 6.3 дахин өсчээ.

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

I. Аймгийн эдийн засаг, нийгмийн зарим гол үзүүлэлтүүд

II. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлын тухай статистикийн тоон мэдээлэл  
( эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар )

Нэг. Хүн ам

- 1.1 Хүн амын тоо, хүйс, байршлаар, оны эцэст
- 1.2 Суурин хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, оны эцэст
- 1.3 Суурин хүн амын нас, хүйсний бүтэц, хувиар, оны эцэст
- 1.4 Суурин хүн амын тоо, сумаар, хүйсээр, оны эцэст
- 1.5 Суурин хүн амын тоо, сумаар, байршлаар, оны эцэст
- 1.6 Өрхийн тоо, сумаар, байршлаар, оны эцэст
- 1.7 Хүн амын тоо, сумаар, байршлаар, 2012 онд
- 1.8 Хүн амын тоо, сумаар, насны ангиллаар, 2012 онд
- 1.9 Хүн амын төрөлт, нас баралт, гэрлэлт цуцлалт, сумаар, оны эцэст
- 1.10 Төрсөн, нас барсан, гэрлэсэн, гэрлэлтээ цуцлуулсан хүний тоо, оны эцэст
- 1.11 1000 хүнд ногдох төрөлт, нас баралт, гэрлэлт цуцлалт, оны эцэст
- 1.12 1000 хүн амд ногдох төрөлт, сумаар, оны эцэст
- 1.13 1000 хүн амд ногдох нас баралт, сумаар, оны эцэст
- 1.14 Өрхийн тоо, сумаар, байршлаар, оны эцэст
- 1.15 Өрхийн нийгмийн зарим үзүүлэлт, сумаар, оны эцэст
- 1.16 Хүн амын нийгмийн зарим үзүүлэлт, сумаар, оны эцэст
- 1.17 Хүн амын шилжилт, хөдөлгөөн, оны эцэст
- 1.18 Хүн амын шилжилт хөдөлгөөн, шилжилт хийгдсэн аймаг, нийслэлээр

Хоёр. Ажиллах хүч

